

**ТӨСВИЙН БАЙНГЫН**  
**ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр, Мягмар гараг*

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-6
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	7-17

---

1.Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.01.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	7-11
2.Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2024.01.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	11-16
3.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /анхны хэлэлцүүлэг/	16-17

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы  
Төсвийн байнгын хорооны 2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр  
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 17 цаг 36 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Даваасүрэн, Б.Жавхлан;

Чөлөөтэй: Ц.Анандбазар, Х.Булгантуяа, С.Ганбаатар, Л.Мөнхбаатар, Ш.Раднаасэд, Ч.Хүрэлбаатар, Б.Чойжилсүрэн.

**Нэг.Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.01.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж, мөн газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Ч.Дондогмаа, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, А.Болортуяа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

**Г.Тэмүүлэн:** Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Б.Баттөмөр, Г.Амартүвшин, Х.Баделхан, Д.Өнөрболор нарын гаргасан, 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 6.5.21 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.5.21.нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүргийн болон аймгийн Засаг даргын Тамгын газар, тэдгээрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумын Засаг даргын Тамгын газар, төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулав.

Дээрх саналтай холбогдуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир гаргасан саналаа татаж, дахин санал гаргав.

**Г.Тэмүүлэн:** Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Б.Баттөмөр, Г.Амартүвшин, Х.Баделхан, Д.Өнөрболор нарын гаргасан, 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 6.5.21 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.5.21.нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүргийн болон аймгийн Засаг даргын Тамгын газар, тэдгээрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумын Засаг даргын Тамгын газар;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 2  
Бүгд: 10  
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Г.Тэмүүлэн:** 2.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 3, 4 дүгээр зүйл болгох:

**“3 дугаар зүйл.**Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах, зам тээврийн салбарын ажилтнуудын хуульд заасан тусгай хувцас” гэснийг “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 15.1 дэх хэсэг” гэж өөрчилсүгэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж үг хэлэв.

**Г.Тэмүүлэн:** 2.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 3, 4 дүгээр зүйл болгох:

**“3 дугаар зүйл.**Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах, зам тээврийн салбарын ажилтнуудын хуульд заасан тусгай хувцас” гэсний дараа “болон “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 15.1 дэх хэсэг” гэж өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.**Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн “, 15.2.3” гэснийг хассугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Г.Тэмүүлэн:** Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал,

зүйл, заалтын дугаарыг нийцүүлж дугаарлах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 17 цаг 56 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төсөл /Засгийн газрын 2024.01.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг даргын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын газрын дарга О.Номинчимэг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн Өрийн удирдлагын тасгийн дарга Л.Эрдэнэбадрах, “Нийслэлийн Орон сууцны корпорац” ХК-ийн гүйцэтгэх захирал М.Говьсайхан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, А.Болортуяа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.*

*Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Г.Тэмүүлэн:** Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, 1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“1 дүгээр зүйл.**Өрийн удирдлагын тухай хуулийн 28<sup>1</sup> дүгээр зүйлийн 28<sup>1</sup>.1 дэх хэсгийн “дотоодын зах зээлд үнэт цаас гаргаж болно.” гэсний дараа “Нийслэл нь гадаад үнэт цаасыг улсын жилийн хөгжлийн төлөвлөгөөнд туссан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, өмнө гаргасан үнэт цаасаа дахин санхүүжүүлэх зориулалтаар Засгийн

газрын өрийн баталгаатайгаар гаргаж болно.” гэж нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга нар үг хийв.

**Г.Тэмүүлэн:** Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“**1 дүгээр зүйл.**Өрийн удирдлагын тухай хуулийн 28<sup>1</sup> дүгээр зүйлийн 28<sup>1.1</sup> дэх хэсгийн “дотоодын зах зээлд үнэт цаас гаргаж болно.” гэсний дараа “Нийслэл нь гадаад үнэт цаасыг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, өмнө гаргасан үнэт цаасаа дахин санхүүжүүлэх зориулалтаар Засгийн газрын өрийн баталгаатайгаар гаргаж болно.” гэж нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	5
Татгалзсан:	5
Бүгд:	10

50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Г.Тэмүүлэн:** Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшингийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	4
Бүгд:	10

60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Г.Тэмүүлэн:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	4
Бүгд:	10

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

*Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.*

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуультай хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

*Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн “Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Г.Тэмүүлэн:** Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, 1.Тогтоолын төслийг 1 дэх заалтын “арга хэмжээг” гэснийг “арга хэмжээ нь Өрийн удирдлагын тухай хуулийн 28<sup>1</sup> дүгээр зүйлийн 28<sup>1</sup>.1, 28<sup>1</sup>.3-д заасан шаардлагыг хангасан тохиолдолд Өрийн удирдлагын тухай хуулийн 18.5.3-т заасан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан төсөл, арга хэмжээг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.Энэ тогтоолыг Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 18 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.*

**Гурав.** “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, А.Болортуяа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн төслийн талаарх ажлын хэсгийг танилцуулгыг танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал үг хэлэв.

**Г.Тэмүүлэн:** “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг найруулгын засвартайгаар батлахыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргав.

**Г.Тэмүүлэн:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 59 минут үргэлжилж, 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр 18 цаг 35 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим,  
17 цаг 36 минут

### ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Г.Тэмүүлэн:** Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн мэндийг хүргэе.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя.

Амартүвшин гишүүн, Өнөрболор гишүүн, Пүрэвдорж гишүүн, Батсуурь гишүүн, Тогтохсүрэн гишүүн, Сандаг-Очир гишүүн, Батжаргал гишүүн, Одонтуяа гишүүд хүрэлцэн ирснээр өнөөдрийн Байнгын хорооны хуралдааны ирц бүрдсэн байна.

Ингээд Төсвийн байнгын хорооны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1 дүгээр асуудал. Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, анхны хэлэлцүүлэг байгаа.

2 дугаарт нь, Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төсөл байгаа.

3 дугаарт, “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл гэсэн ийм 3 асуудалтайгаар хэлэлцэх асуудлаа батлах гэж байна.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу? Хэлэлцэх асуудалд орцгооё.

**1 дүгээрт, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, анхны хэлэлцүүлгийг хийж эхэлье.**

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг оруулаарай.

Чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу зүйл бүрээр хэлэлцэнэ гээд заасан байгаа.

Дээрээс нь хуулийн төслийн тухайн зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас болоод бусад оролцогчоос асуулт асууж болно гэж заасан байгаа.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар санал хураалтыг явуулж эхэлье. Гишүүдэд саналын төслүүдийг тараасан байгаа байх, тийм ээ. Тараасан байгаа юм байна.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулаад асуулт асууж, зарчмын зөрөөтэй санал гаргах гишүүд байна уу? Сандаг-Очир гишүүн байна. Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

**Ц.Сандаг-Очир:** Хэлэлцэх эсэх дээр би саналаа хэлж байсан. Төслийн 1 дүгээр зүйлийн 6.5.21 дэх заалтад доор дурдсанаар найруулах гээд 6.5.21 нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүргийн болон аймгийн Засаг даргын Тамгын газар, тэдгээрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумын Засаг даргын Тамгын газар, төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага гэсэн зарчмын зөрөөтэй саналыг оруулж байна.

**Г.Тэмүүлэн:** Сандаг-Очир гишүүн зарчмын зөрөөтэй саналын томъёолол гаргаж байгаа юм байна. 6.5.2.1 дэх



заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах гээд 6.5.21 дээр нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүргийн болон аймгийн Засаг даргын Тамгын газар, тэдгээрийн эрхлэх судлалын хүрээний агентлаг, сумын Засаг даргын Тамгын газар, төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага гэж гаргаж байгаа юм байна. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир, Баттөмөр, Амартүвшин, Баделхан, Өнөрболор гэсэн байна.

Ажлын хэсэг гараа өргөж байна. 2 номер. Ажлын хэсгийн микрофон.

**Б.Баасандорж:** Байнгын хорооны дарга, гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Зүгээр саяын саналын томъёолол дээр зүгээр гишүүд маань хэрвээ хүлээж авбал энэ яг нөгөө хууль тогтоомжийн тухай хуулийн бичилт, техник гэж байгаа. Тэгэхээр 6.5.21 бол саяын Сандаг-Очир гишүүний санал. Батжаргал гишүүний санал бол яг болж байгаа. Энэ бол нөгөө засаг захиргааны нэгжээр буюу аймаг, нийслэлийн Засаг дарга, Тамгын газартай холбоотой ажлууд төрийн үйлчилгээг тасралтгүй хүрэхэд нь машины асуудлыг нээж өгч байгаа.

Яг энэ асуудалд орон нутаг, аймаг, нийслэлийг хөндсөн заалт дээр төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага гээд тэс хөндлөн өөр. 6.5 чинь өөрөө ингээд яг байгууллагыг салбар салбараар нь ангилчихсан байгаа шүү дээ. Тэгсэн чинь орон нутаг, аймаг, нийслэл дотор төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага гээд шууд оруулчих юм бол энэ хуулийн техникийг эвдэх гээд байна. Бичилтийг нь эвдэх гээд байна. Тэгэхээр хэрвээ хууль тогтоогчид хэрвээ үүнийг явал үүнийг тусад нь авч үзээч ээ, ямар ч байсан энэ 6.25-ын, 6.5.21 дотор төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага гэж бол орвол нөгөө техник эвдэгдэнэ.

2-т нь, Засгийн газраас өргөн мэдүүлсэн хуулийн төслийн концептод бол энэ байгууллага бол байхгүй байгаа.

**Г.Тэмүүлэн:** Ойлголоо. Техник бичилт талаасаа агуулгын хувьд зөрчилтэй болох гээд байна гэдэг зүйлийг ярьж байна, тийм ээ. Агуулгын хувьд ер нь зарчмын хувьд болох юм уу? Үүнийг Засгийн газар яагаад эхнээсээ оруулж ирээгүй юм бол. Эрдэм шинжилгээний байгууллагуудыг орхигдуулж орж ирсэн гэдэг юм уу, энэ Засгийн газар, БСШУЯ-наас л үүнийг бас хөндөж гаргаж ирж тавиад байна уу гэж хараад байгаа юм.

1 номероос Санжаадорж дарга.

Сангийн яам Санжаадорж, Тэмүүлэн даргын асуултад хариулъя. Засгийн газар дээр хэлэлцэхдээ тэргүүн ээлжид бол Улаанбаатар хотоос бусад газруудад өөрөөр хэлбэл аймаг, аймгийн Засаг даргын Тамгын газар, сумдад бол энэ автомашин хэрэглэх зохицуулалтыг бол оруулж ирсэн.

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудыг оруулж ирээгүй. Энэ нь бол яг бодлогын хувьд тэгж орж ирээгүй. Нөгөө өмнө нь бас тайлбар бид хэлж байсан шиг бас нөгөө ажлын хэсэг гараад ажиллахад бол яг шинжлэх ухааны байгууллагууд болох бас санал, энэ санал бас өгч байгаагүй, ийм санал байгаад байна.

**Г.Тэмүүлэн:** Тэгэхээр хууль 40.3 дээр. Дэгийн тухай хууль дээр хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг хэлэлцэхдээ дэгийн тухай хуулийн 40.3.5 буюу хуулийн төсөл, зүйл, хэсэг, заалт, дэд заалт нэмэх гэдэг чинь хориглочихсон юм байна. Тэгэхээр сая нөгөө. Тэгье. Тэгвэл Сандаг-Очир гишүүн микрофонд үгээ хэлье.

**Ц.Сандаг-Очир:** Саяын гаргасан зарчмын зөрөөтэй санал маань дэгийн хуулийн тодорхой заалтыг зөрчиж байна

гэж үзэж байгаа бол төрийн өмчит эрдэм шинжилгээний, саяын гаргасан зарчмын зөрөөтэй саналын томъёоллоо татаад тэгээд ахиад дэгийн хуульд нийцүүлээд санал хураалгая.

**Г.Тэмүүлэн:** Сандаг-Очир гишүүн тэгвэл шинэ томъёоллоо та унших уу, тийм ээ. Саяынхыг хасаад. Сандаг-Очир гишүүн, саналын томъёолол.

**Ц.Сандаг-Очир:** 6.5.21 Нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүргийн болон аймгийн Засаг даргын Тамгын газар, тэдгээрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумын Засаг даргын Тамгын газар. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир, Баттөмөр, Амартүвшин, Баделхан, Өнөрболор.

**Г.Тэмүүлэн:** Ок, ойлголоо. Тэгвэл саяын Сандаг-Очир гишүүний гаргасан зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураалтыг явуулж эхэлье. Саяын саналын томъёоллыг дэмжье гэдгээр санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалт 80 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулаад асуулт асууж, зарчмын зөрөөтэй санал гаргах гишүүд байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрөөтэй санал гаргах гишүүд байна уу? Батжаргал гишүүн байна. Батжаргал гишүүнээр тасалъя. Батжаргал гишүүний микрофоныг өгье.

**Ж.Батжаргал:** Хуулийн төслийг Байнгын хороон дээр хэлэлцэх эсэхийг хэлэлцэж байх явцад тодорхой саналууд илэрхийлсэн. Түүнийхээ дагуу зарчмын зөрөөтэй санал гаргах гээд байгаа юм. Энэ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн Эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах, зам

тээврийн салбарын ажилтнуудын хуульд заасан тусгай хувцас гэснийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 15.1 дэх хэсэг гэж өөрчилсүгэй л гэж л оруулах гээд байна л даа.

Энэ өнгөрсөн жил бас яг энэ хуулийг хэлэлцэж байх явцад энэ нэг төрийн өмнөөс чиг үүрэг гүйцэтгэдэг бас хувцас хунараараа ялгагддаг ийм байгууллагууд гэдэг юм уу, эс үгүй бол хөдөлмөрийн аюулгүй байдал, ажиллагаа хангагддаг байгууллагуудын энэ хувцасны асуудал хаягдаад, энэ хууль дээр зөвхөн дүрэмт хувцасны асуудал яригдаад, түүгээрээ бүх бусад байгууллагуудынхаа бүх хувцсыг хаачих гээд байсан учраас санал гаргаж хамаарах 8.1-д хамаарахгүй гэж оруулж байсан юм. Тэгсэн энэ жил дахиад хасахаар ороод ирчихсэн юм билээ. Тийм учраас үүнийг ингэж томъёолж оруулах нь зүйтэй байна л гэсэн санал байна л даа.

**Г.Тэмүүлэн:** Ойлголоо. Тэгвэл 3 дугаар зүйл дээр доор дурдсанаар өөрчлөн найруулж Батжаргал гишүүний хэлсэн томъёоллыг. Санал байна уу? Баасанжаргал дарга. Баасандорж 2 номер.

**Б.Баасандорж:** Тийм. Хэрвээ гишүүд маань зөвшөөрвөл зүгээр томъёоллын хувьд ингэж болох уу? Яах вэ, надад бол санал хэлэх эрх байхгүй. Шийдвэрийг бол гишүүд гаргах эрхтэй. Тэгэхээр зүгээр томъёоллын хувьд яг энэ эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах, зам тээврийн салбарын ажилтнуудын гэсний дараа болон хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг гээд нэмээд бүр тодорхой болгоод. Энэ 3 субъект нь байж байг. Ингэхгүй бол би Батжаргал гишүүн ээ, яагаад үүнийг хэлээд байна гэхээр яг Байгаль орчны тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль дээр байгаль хамгаалагч дүрэмт хувцас өмсөнө гээд заачихсан байгаа байхгүй юу. Тусгай хувцас гэж байхгүй.

Тэгэхээр энэ хууль дээрээ тусгай хувцас яг түүнийг нь тодорхой хэлээд өгчих юм бол Төрийн хэмнэлтийн хуулиар өөр хуульд өөрөөр заасан ч гэсэн энэ хуулиа хэрэглэнэ гэж байгаа учраас энэ дээрээ бүр тодорхой таны саналыг би дэмжээд, дэмжээд байгаа юм. Ер нь бол, бүр тодорхой, энэ 3 субъектээ бичээд дээр нь таны гаргасан Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хуулийн 15.1-ийг давхар биччих юм бол нөгөө ТҮК-ийн ажилтнууд маань, эрчим хүчний ажилтнууд маань, харилцаа холбооны ажилтнууд маань тусгай хувцас хэрэглэх нь тодорхой болчих юм, аль аль нь. Тийм, гэсний дараа болон Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 гээд. Тэгэхээр аль аль нь бүр тодорхой болчих юм. Тийм.

**Г.Тэмүүлэн:** Батжаргал гишүүн саналын томъёоллоо шинэчилж уншъя. Батжаргал гишүүн.

**Ж.Батжаргал:** Тэгэхээр 3 дугаар зүйл дээр ажлын хэсгийн гишүүдээс гарсан саяын томъёоллын дагуу гэснийг гэдгийг нь болон гээд тэгээд холбоос хийх нь зөв юм байна, тийм үү? Би тийм, тэгж ойлголоо.

Энэ томъёолол орж ирж байгаатай холбогдуулаад хуулийн төсөл дээр 4 дүгээр зүйл нэмэгдэж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн 15.2.3 гэснийг хассугай гэсэн ийм шинэ заалт орох гээд байгаа юм. Хоёулаа давхар хасалттай явсныг нь бид өмнө нь ингэж өөрчилсүгэй гээд оруулчихсан учраас хассугай гэсэн хэсгийг нь 4 дэх заалт болгоод оруулчхаж байгаа юм. Ийм.

**Г.Тэмүүлэн:** Ойлголоо. Тэгвэл тэгээд Батжаргал гишүүний саналын томъёоллоор санал хураалтыг явуулъя. Батжаргал гишүүний сая уншсан саналын томъёоллыг дэмжье гэдэг саналын томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт, гишүүд ээ.

Санал хураалт 70 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбоотой асуулт асуух, зарчмын зөрөөтэй санал гаргах гишүүд байна уу? Алга байна.

Ингээд дээрх саналууд дэмжигдсэнтэй холбогдуулаад төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулж, төслийн агуулга зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал гаргасан гишүүн Батжаргал гишүүн байна. Санал хураалт.

Санал хураалт 70 хувиар дэмжигдлээ.

Ойлголоо. Тэгэхээр дэгийн хуулиар болохгүй л гэдэг тайлбарыг л манайхан тавиад байгаа юм Хууль, эрх зүйн газраас. Ойлголоо.

Ингээд, өөр саяын тэр Батжаргал гишүүний хэлээд байгаа саналыг бол оруулах ямар нэг хууль, эрх зүйн гаргалгаа байхгүй юу. Хууль эрх зүйн газрынхан, зөвлөхүүд.

Үлдсэн. Тэгээд эх барьж байгаа зөвлөх Хууль, эрх зүйн газраас болохгүй гэсэн саналыг хэлж байгаа учраас дэгээ баримтлаад явахаас аргагүй байна.

Ингээд Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж, хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Ингээд хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг хийсэн талаар Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир гишүүн

униших уу? Сандаг-Очир гишүүн танилцуулъя.

17.56 цаг

Дараагийн асуудалдаа орцгооё. 2 дахь асуудал.

**Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж эхэлье.**

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг оруулаарай.

Мөн бас зүйл бүрээр нь хэлэлцэнэ гэсэн байгаа. Тухайн зүйлтэй холбогдуулж хууль санаачлагчаас болон бусад оролцогчоос асуулт асууж болно гэж дэгийн хууль дээр бас заасан байгаа.

2 дугаар асуудал дээр орё. 2 дугаар асуудалтай холбогдуулаад Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр санал хураалтыг явуулж эхэлье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрөөтэй санал гаргах гишүүд байна уу? Байхгүй байна уу.

1 дүгээр зүйл дээр нэг ийм зарчмын зөрөөтэй саналын томъёолол гаргая гээд саналын томъёолол байж байгаа.

1 дүгээр зүйл дээр Өрийн удирдлагын тухай хуулийн 28-ын чирээс 1 дүгээр зүйлийн 28-ын чирээс 1 дэх хэсгийн дотоодын зах зээлд үнэт цаас гаргаж болно гээд заасны дараа нийслэл нь гадаад үнэт цаасыг улсын жилийн хөгжлийн төлөвлөгөөнд туссан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, өмнө гаргасан үнэт цаасаа дахин санхүүжүүлэх зориулалтаар Засгийн газрын өрийн баталгаатайгаар гаргаж

болно гэж нэмсүгэй гэсэн нэг ийм саналтай байна.

Нямбаатар даргын микрофоныг өгье. 3 номер.

**Х.Нямбаатар:** Байнгын хорооны гишүүдийн энэ оройн амгаланг эрье. Энэ саяын саналын зөрөөтэй томъёоллыг оруулбал энэ өмнө нь батлагдсан улсын хөгжлийн төлөвлөгөөтэйгөө зөрчилдөж байгаа юм. Тийм, улсын хөгжлийн төлөвлөгөө дээр юу гэж орсон бэ гэвэл 6.1.4.3-д Сэлбэ сэргэлт төслийг хэрэгжүүлэх гээд улсын хөгжлийн төлөвлөгөө дээр тусчихсан байгаа юм. Энэ Сэлбэ сэргэлт гэдэг нь зөвхөн нөгөө Сэлбийн гол дагуу авто зам барих төсөл байхгүй юу. Бид нарын энэ Сэлбэ дэд төв гэдэг бол улсын хөгжлийн төлөвлөгөөнд тусаагүй байгаа. Тэгэхээр энэ гарснаараа Улсын Их Хурлын тогтоолтойгоо зөрчилдөх ийм нөхцөл байдал үүсэж байгаа учраас тэр улсын хөгжлийн төлөвлөгөөнд туссан гэдэг тэр томъёоллоор санал хураалгавал одоо батлагдан гарах хууль, өмнө нь батлагдсан Улсын Их Хурлын тогтоол 2 ийм зөрчил үүсэж байгаа юм. Үүнийг энэ тогтоолдоо ийм хуулийн зөрчил үүсэхээр байгаа гэдгийг та бүхэн хараад, тэр улсын хөгжлийн төлөвлөгөө гэдэг үгээ аваад хураалгахад бол бусад нь боломжтой.

**Г.Тэмүүлэн:** Харин тийм байна. Бид хэд нөгөө, би өчигдөр анхны хэлэлцүүлэг дээр биш ээ, хэлэлцэх хэсэг дээр байж чадаагүй. Байнгын хороо юун дээр орж чадаагүй юм. Тэгээд бид хэд болохоор зүгээр нөгөө 4.1.4 дээр байгаа юугаар Сэлбэ сэргэлт төслийг хэрэгжүүлэх гээд энэ төслийг чинь бол гэж хараад байгаа байхгүй юу. Тэгэхээр та хэдийг бонд гаргаж байгаа энэ асуудал маань яг үүнтэй уялдаатай гол энэ Сэлбэ төслийг хэрэгжүүлэх хүрээнд, дээрээс нь энэ хүрээнд энэ ногоон орон сууц болоод шинэ бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, инженерийн орон сууц болоод орон сууцын хангамжийг

нэмэгдүүлэх хүрээнд хийх гэж байгаа ажил байна уу гэж хараад байгаа байхгүй юу. Тэгэхээр үндэсний жилийн хөгжлийн төлөвлөгөө дээр туссан ажлаас тусдаа өөр ажил гэж ойлгож болох юм уу?

Нямбаатар сайд.

**Х.Нямбаатар:** 2024 оны нийслэлийг хөгжүүлэх төлөвлөгөөнд энэ тусчихсан явж байгаа асуудал байгаа. Тэгээд бид нар яг одоо энэ хууль батлагдаад энэ тогтоол гарснаараа шууд бонд гаргах гэж байгаа зүйл биш. Энэ асуудлыг ингээд хуулиар эрхээ авчхаад, тэгээд засаг дээр дахиж шийдэл гаргаад, засаг 3,5 дотроо хэдийг нь нийслэлд хуваарилж баталгаа гаргах вэ гэдгээ дараа нь Засгийн газар өөр дээрээ шийдлээ гаргахаар ийм юутай байгаа. Бид нар гол нь одоо оруулж ирж байгаа нь ингээд өнөөдөр маргааш чуулган завсарлаад явчихаар бид нар 3 сарын 15-наас хойш дахиад энэ процесс цаг хугацаа алдах байгаа учраас бид нар 2 3 сардаа гадаад зах зээл дээр нөгөө гаднын санхүүгийн зөвлөхүүдээ ажиллуулах ийм орон зай цаг хугацааг л чуулганы завсарлагаа дундуур л авахаар ийм оруулж ирсэн юм.

Сая Батжаргал гишүүний ярьж байгаа зүйл байна лээ. Энэ нөгөө улсын хөгжлийн төлөвлөгөөнд туссан эсэх гээд. Энэ дээр бид нар нийслэлийн хөгжлийн төлөвлөгөө 2024 онд хөгжүүлэх төлөвлөгөө дээр үүнийг тусгаад явчхаж байгаа юм, шалгуур дээр. Энэ нөгөө юутайгаа, өрийн удирдлагын, тэр бусад бүх шаардлагуудыг хангасны хойно Засгийн газар орон нутаг, нийслэлийг бонд гаргах эрхийг нээж өгнө өө гэдэг ийм агуулгатайгаар сая засаг дээр ярилцсан.

**Г.Тэмүүлэн:** Бид хэд яах вэ, энэ гол нөгөө санаа зовоод байгаа юу нь болохоор ингэж л сая яасан юм. Яах вэ, нөгөө энэ дээр оруулж, улсын хөгжлийн гэж оруулаад байгаа нь, тийм яг яах вэ,

зүгээр энэ дээр угаасаа бид нар чинь аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө гэж гэдэг энэ өөрөө улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан байна. Тэгээд тэр нь тухайн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх төсөв санхүүгийн эх үүсвэрийг тусгасан төсөл, арга хэмжээ буюу төлөвлөлтийн баримт бичгийг хэлнэ ээ гээд нөгөө хуулийнхаа 4.1.14 дээр тусгачихсан байгаад байгаа юм. Тийм.

Байз, нэг зүйл яах вэ, бид нар хэлээд байгаа зүйл, нөгөө улсын жилийн хөгжлийн төлөвлөгөө дээр. Тэгэхээр энэ тусгачихсан төлөвлөгөөт ажлаас өөр ажил болж таарах гээд байна шүү дээ. Тэгэхээр үүнийг жишээ нь улсын жилийн хөгжлийн төлөвлөгөөгөө өөрчилж оруулж ирж болоогүй юм уу. Улсын Их Хурлаар баталсан юугаа. Түүн дээр чинь саяын.

Сангийн яам. 1 номер.

Сангийн яамны хэлтсийн дарга Тулга гишүүдэд тайлбар хийе. Энэ Өрийн удирдлагын хуулийн түрүүн Батжаргал гишүүний дурдсан 4 шаардлага дээр төсөвт тусгачихсан байх, төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн байх, хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигт тусгачихсан байх гэж байгаа юм. Энэ дээр бол улсын гэж байхгүй. Хөгжлийн бодлого баримт төлөвлөлтийн баримт бичиг байгаа. Тэр хөгжлийн бодлого гэдэг нь юу вэ гэхээр улс, салбар, салбар хооронд болон бүс орон нутгийн түвшинд урт, дунд, богино хугацаанд хөгжлийн тодорхой асуудлаар ахиц дэвшилд хүргэхээр дэвшүүлсэн хэмжигдэхүйц зорилго, зорилт, тэдгээрийн суурь түвшин, хүрэх үр дүн, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, санхүүжилтийн эх үүсвэрийг баталгаажсан төсөв хэрэгжилтийн хянан шалгуур үзүүлэлтийг тусгасан эрх бүхий этгээдээс баталсан баримт бичгийг хэлнэ ээ гэж байгаа юм.

Тэгэхээр энэ чинь нөгөө нэг анх өргөн барьчихсан байгаа нийслэлийн хөгжлийн бодлого төлөвлөлт гэдэгтэй нь бол яг өрийн удирдлага бол нийцээд явж байгаа.

Энэ дээр бас нэмэлт тайлбар хийхэд орон нутгийн өр нь угаасаа Засгийн газрын өр дотор ордог. Энэ дээр гишүүн ээ, Засгийн газар баталгаа гаргасан гаргаагүй, нийслэл үнэт цаас гаргахад энэ Засгийн газрын өр дотор өөрөө хамаараад явдаг. Засгийн газрын өр дотор орон нутгийн өрөнд багтдаг учраас энэ дээр Засгийн газар баталгаа гаргасан гаргаагүй нийслэл гадаад үнэт цаас гаргах юм бол энэ бол Засгийн газрын гадаад өрийг нэмэгдүүлэх л асуудал байгаа. Баталгаа гаргаж байгаа бол. Энэ дээр дарга аа, баталгаа гаргаж байгаа ерөнхий л гол шалтгаан нь бол хүүгийн зардлыг бууруулах гэж л Засгийн газар баталгаа гаргаж байгаа тийм л асуудал байгаа. Түүнээс бол Засгийн газрын өр дотор өр нь угаасаа багтаад л явж байгаа.

**Г.Тэмүүлэн:** Яах вэ, зүгээр гол яриад байгаа юм чинь юу шүү дээ. Бид хэд нөгөө сая Монгол Улсын жилийн хөгжлийн төлөвлөгөө гээд харахаар нөгөө 6.1.4.3 дээр гээд Сэлбэ сэргэлт төслийг хэрэгжүүлэх гээд энэ маань яг нэрээрээ суучихсан байгаад байгаа байхгүй юу. Тэгээд бид нар үүнийг л юм байна гэж ерөнхийдөө агуулгын хувьд ойлгоод байгаа. Тэгээд яг Улсын Их Хурлаар батлагдсан улсын жилийн хөгжлийн төлөвлөгөө дээр тусгагдсан төсөл бол яг энэ 502 тэрбум гэдэг төгрөгөөр байгаад байгаа байх байхгүй юу. Гэтэл одоо та бүхний ярьж байгаа зүйл маань бол арай өөр төсөл болж таараад нийслэлийнхээ хөгжлийн хөтөлбөртөө туссан төлөвлөгөө гэж яриад байгаа юм. Тэгэхээр улсын хөгжлийн төлөвлөгөө гэдэг чинь өөрөө юунаас бүрдэх вэ гэхээр энэ өөрөө аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөнөөсөө бүрдэнэ ээ. Тэгээд түүн дээр үндэслэж улсын хөгжлийн

төлөвлөгөө суурилж гарч ирнэ ээ гэсэн ийм зүйл байгаад байгаа юм.

Тэгэхээр угаасаа нэг талдаа хэрэв энд суусан энэ 502 тэрбум төгрөгийн төсөл биш бол энэ нэг талдаа энэ Монгол Улсын 2024 жилийн хөгжлийн төлөвлөгөө дээр тодорхой хэмжээнд өөрчлөлт оруулах л шаардлагатай болчихоод байгаа юм. Сая Эдийн засгийн хөгжлийн яамнаас, Сангийн яамнаас байсан уу. Сангийн яамнаас Сангийн яамнаас байсан тийм ээ. Тэгэхээр тэр нийслэлийн хөгжлийн төлөвлөгөө гэдэг чинь угаасаа л энэ улсынхаа жилийн хөгжлийн төлөвлөгөөнд нийцсэн байх ёстой болчихоод байгаа байхгүй юу. Тэгээд тэр зарчмыг л бид нар яриад ерөнхийдөө энэ улсын жилийн хөгжлийн төлөвлөгөөнд батлагдсан энэ юундаа хийгээч ээ, хуулийн хүрээнд. Ийм агуулгыг нь хийчихвэл яасан юм л гэсэн санаа байсан юм.

Сэлбэ сэргэлт, төсөл гээд тийм ээ. Түүгээрээ байгаа. Тэгээд та хэд энэ нэрээр нь.

Би яг, тэгвэл яах вэ, бид нар санаа зовоод л ингээд яагаад байгаа зүйл маань яах вэ, дараа нь энэ чинь бас нөгөө төсвийн сахилга бат, хяналт хариуцлагын л асуудлууд. Тэгээд л өмнөх яах вэ, та хэдийг бас л мэдээж ажил үүрэг хариуцаж байгаа хүмүүс бол хариуцлагатай ажиллана гэдэгт бол итгэж байгаа. Нөгөө талдаа дараа дараадаа бас дахиад энэ төсөв санхүүгийн сахилга бат, хяналт, хариуцлагын асуудал болоод яригдах учраас яг хуулийн дагуу энэ асуудлууд маань хийгдсэн эсэх асуудал дээр хуультайгаа нийцэж байгаа эсэх дээр л санаа зовниж л асуугаад байгаа юм.

Хөгжлийн энэ бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 18.5.4 дээр яг гол нь нөгөө зураг төсөв, ТЭЗҮ баталгаажуулсан байх гэдэг асуудлыг яригдаад байгаа шүү дээ. Тэгэхээр яг энэ зураг төсөв, ТЭЗҮ болоод мөнгөн дүнгийн

асуудлууд бол баталгаажсан гэж ойлгож болох уу?

3 номер.

**Х.Нямбаатар:** Би түрүүн нөгөө микрофонгүй ярьсан учраас энэ нөгөө протоколд үлдэх учраас яг Өрийн удирдлагын тухай хуулийн 18.5.3-д заасны дагуу хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигт тусгасан байх гэдэг томъёоллоор санал хураачихвал Улсын Их Хурлын тогтоол, батлагдан гарах хууль 2 зөрчилгүй болно гэдгийг 1 дүгээрт хэлэх гэсэн юм.

2 дугаарт, Тэмүүлэн гишүүний асуусан асуултад хариулахын тулд Сангийн яам Засгийн газар бид нарыг энэ нөгөө ТЭЗҮ, зураг төсөвтэй болсон хойно бид нар зөвшөөрлөө өгнө гэсэн юм. Тийм учраас бид нар Сэлбэ дэд төвийн барилга ажлын зургийг зурах олон улсын нээлттэй тендер зарлачихсан. Саяхан миний авсан мэдээллээр богино лист үүсчихсэн байгаа. Тэгээд богино листээсээ цаашаа үргэлжлүүлээд 30 хоногийн дараа сонгон шалгаруулалтын ажил хийнэ. Тэгэхээр энэ ойролцоогоор 3 сарын дундуур гэхэд энэ дуусах байх. Энэ үед бид нар нөгөө road шoугаа хийх ийм төлөвлөгөөтэй л явж байгаа. Тэгэхээр Сангийн яам бол манайхыг хэзээ ч энэ хөгжлийн бодлогын Өрийн удирдлагын тухай хуульд заасан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд бонд гаргах зөвшөөрөл, түүний хязгаарыг баталж өгөхгүй ээ гэдэг ийм зарчимтай явж байгаа.

**Г.Тэмүүлэн:** Ойлголоо. Тэгвэл тэгээд саяын 1 дүгээр зүйлийг би доор дурдсанаар өөрчлөн найруулах саналыг дахиад уншиж танилцуулъя. Энэ эх барьсан зөвлөхүүдээс болоод нөгөө Их Хурлын Хууль, эрх зүйн газраас гаргаж байгаа санал байгаад байгаа юм.

Өрийн удирдлагын тухай хуулийн 28-ын чирээс 1 дүгээр зүйлийн 28-ын чирээс 1.1 дэх хэсгийн дотоодын зах

зээлд үнэт цаас гаргаж болно гэсний дараа нийслэл нь гадаад үнэт цаасыг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, өмнө гаргасан үнэт цаасаа дахин санхүүжих зориулалтаар Засгийн газрын өрийн баталгаатайгаар гаргаж болно гэсэн томъёоллоор. Тусгасан. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигт тусгасан төсөл, арга хэмжээг. Өргөн барьсан нь бол хууль дээрээ юу, та хэдийн өргөн барьсан нь дээр үү. Ойлголоо. Ок. Ийм байдлаар тэгвэл саналын томъёоллыг гаргаж байна.

Ингээд саяын уншсан саналын томъёоллын дагуу болж байна гэж үзэж байна, тийм ээ.

Санал хураалтыг тэгвэл явуулъя. Саяын уншсан томъёоллын дагуу санал хураалтыг дэмжье гэдэг саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал гаргах гишүүн байна уу? Байхгүй юу. Амартүвшин гишүүнд микрофон өгье.

**Г.Амартүвшин:** Саяын санал хураалтыг дахин явуулж өгнө үү.

**Г.Тэмүүлэн:** Саяын санал хураалтыг хүчингүй болгох санал хураалтыг явуулъя. Амартүвшин гишүүний гаргасан саналаар санал хураалт.

60 хувиар дэмжигдлээ. Энэ санал дэмжигдсэн тул өмнө нь уншсан саналын томъёоллоор дахин санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

60 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асууж асууж, зарчмын зөрөөтэй санал гаргах гишүүд байна уу? Алга байна.

3 дугаар зүйлтэй холбогдуулж, тийм байна. 2 дугаар зүйл тийм байна, уучлаарай.

Ингээд санал хураалтыг явуулж дууслаа.

Өрийн удирдлагын тухай хуультай хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар санал хураалтыг явуулж эхэлье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрөөтэй санал гаргах гишүүд байна уу? Алга байна.

Санал хураалтыг явуулж дууслаа.

Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн “Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар санал хураалтыг явуулж эхэлье.

Тогтоолын төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулаад асуулт асууж, зарчмын зөрөөтэй санал гаргах гишүүд байна уу?

Энэ байна уу, энэ үү тийм ээ. Тийм байна. Тэгэхээр түрүүний томъёололтой энэ нийцэж байгаа юу. Болох уу. Үүгээр уншиж. Дахиад засах уу энэ дээр, томъёолол өөрчлөх юм байгаа юу? Ок.

Тогтоолын төслийг 1 дэх заалтын арга хэмжээг гэснийг арга хэмжээ нь Өрийн удирдлагын тухай хуулийн 28-ын чирээс 1 дүгээр зүйлийн 28-ын чирээс 1.1, 28-ын чирээс 1.1.3-д заасан шаардлагыг хангасан тохиолдолд Монгол Улсын хөгжлийн 2024 онд төлөвлөгөөнд туссан төсөл, арга хэмжээг гэж өөрчлөх гэдэг томъёолол байна, тийм ээ.

Түрүүний унисан томъёоллоор бас нийцүүлж өөрчлөх асуудал болох юм байна.

Ийм юм байна шүү. Тогтоолын төслийг 1 дэх заалтын арга хэмжээ гэснийг арга хэмжээ нь Өрийн удирдлагын тухай хуулийн 28-ын чирээс 1.1 дүгээр зүйлийн 28-ын чирээс 1.1, 28-ын чирээс 1.1.3-д заасан шаардлагыг хангасан тохиолдолд Өрийн удирдлагын тухай хуулийн 18.5.3-д тусгасан төсөл, арга хэмжээ гэх юм байна тийм ээ.

Энэ Нямбаатар сайд, Нямбаатар дарга та нэг дахиад нэг сонсоодхооч. Энэ айхтар зөрчилгүй гэж үзвэл ингээд саналын томъёоллоор явчихъя л гэсэн юм. Дахиад нэг нь саяын нөгөө тогтоолын төслийн 1 дэх заалтын арга хэмжээг гэснийг арга хэмжээ нь Өрийн удирдлагын тухай хуулийн 28-ын чирээс 1 дүгээр зүйлийн 28-ын чирээс 1.1, 28-ын чирээс 1.3-д заасан шаардлагыг хангасан тохиолдолд Өрийн удирдлагын тухай хуулийн 18.5.3-д заасан хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигт тусгасан төсөл, арга хэмжээг гээд түрүүнийхээ хуульд зааснаараа л гэж байгаа юм. Тэгээд энэ нөгөө Хууль зүйн хэлтсээсээ хэлтсийнх нь дарга болоод газрын дарга нар нь л ингэж л өгч байгаа шаардлагын асуудлууд байгаад байгаа юм.

Ингээд үүгээр санал хураалтыг явуулчихъя, тэгэх үү. Найруулгын зүйл байвал дараа нь бас наашилаад явчихъя. Үүнийг энэ унисан томъёоллоор санал хураалтыг явуулж, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт.

60 хувиар дэмжигдлээ.

Тогтоолын төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Тогтоолын 2 дугаар заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах гэсэн бас



ийм санал байна. Энэ тогтоолыг Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн байна.

Энэ томъёоллыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

Санал хураалт 60 хувиар дэмжигдлээ.

Хууль болоод тогтоолын төслүүдийг хэлэлцэж дууслаа.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг хийсэн талаарх Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Амараа гишүүн унших уу. Гишүүд байна уу. Өнөрболор гишүүн.

Баярлалаа, ажлын хэсэгт.

18.28 цаг

Дараагийн асуудалдаа орцгооё.

**“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл байгаа.**

Ажлын хэсгийн танилцуулгыг та бүхэнд уншиж танилцуулъя.

Татварын шинэчлэл болоод иргэдээс гаргасан олон нийтийн саналтай холбогдуулаад Улсын Их Хурал болон Төсвийн байнгын хорооноос бас ажлын хэсгүүд ажилласан байгаад байгаа. Үүнтэй холбоотойгоор бас 2 ажлын хэсэг гарсан. Ажлын хэсэг нийт хугацаанд нийтдээ нэг 15 орчим удаагийн уулзалт зохион байгуулаад, 12 холбоод болон 300 орчим удаа татвар төлөгчийн төлөөлөлтэй уулзаж, тодорхой аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд учирч байгаа бас хүндрэл, бэрхшээлийн асуудлуудаар бол санал солилцож,

саналыг авсан байгаад байгаа. Нийтдээ 100 гаруй саналуудыг ирүүлсэн байна.

Ингээд татвар төлөгчдөөс ирүүлсэн саналуудаас хамгийн түрүүнд нэн тулгамдаж байгаа асуудал нь энэ Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор гарсан хэм хэмжээний актууд нь татварын хуулиасаа давсан байдаг. Мөн төрийн байгууллагаас тогтоосон өндөр хэмжээний үйлчилгээний хөлс, төлбөр, хураамж нь татвараасаа ялгаагүй санхүүгийн ачааллыг үүсгэж байна. Тэр хэмжээгээр татварын зардлыг нэмэгдүүлж байна гэсэн саналыг илэрхийлээд байгаа. Энэ үүднээс бас ажлын хэсгийн зүгээс энэ татварын шинэчлэл хийх зорилттой холбогдуулж, эхний ээлжид энэ “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулах нь зүйтэй гэж үзсэн байгаа.

Тэгээд энэ тогтоолын төслийг энэ төслийг та бүхэнд бас тараасан байгаа. Ингээд ажлын хэсгээс боловсруулсан тогтоолын төслийг бас хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү гэсэн энэ саналыг бас та бүхэнд танилцуулж байна.

Тогтоолын төсөлтэй холбоотойгоор асуулттай гишүүд байна уу? Батжаргал гишүүн. Батжаргал гишүүн.

**Ж.Батжаргал:** Хууль зүйн газар л хариулах байх даа. Энэ тогтоол чинь уг нь бас жоохон тэмдэглэлтэй энэ тэр байж болдог л доо. Тэгэхээр энэ гарах гэж байгаа тогтоол бол дан дамаа тэмдэглэлтэй гармаар байгаа юм. Тэмдэглэх нь гэж байгаад. Тэр иргэд, олон байгууллагуудтай уулзлаа. Тэндээс татварынхаа хууль тогтоомжоос давчихсан ийм ийм юмнууд байгаад байна гээд хэчнээн байгууллагууд дурдчихлаа эд нар гэдгээ хэлээд, тэгээд ийм ийм заалтыг үндэслээд тогтоох нь гээд хэлчихвэл бүх юм тодорхой болчихож байгаа байхгүй юу.

Тэгээд Засгийн газарт өгч байгаа чиглэлээ дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасугай гэх юм уу, ерөөсөө татварын юуны таатай орчин гэдэг юм уу, ээлтэй орчин бүрдүүлэх чиглэлээр дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг даалгасугай ч гэдэг юм уу. Ийм бас нэг тийм утга санаа нь илэрхийлэгдсэн байдлаар өгөгдөөд тэгээд энэ заалт нь явах ёстой байх.

2 дахь заалт чинь манайтай эрхлэх асуудлынхаа хүрээнд Их Хуралтай хамааралтай байгууллагуудын асуудлыг бол Засгийн газарт бид чиглэл өгч шийдүүлж болохгүй. Өөрсдөө шийдэх тухай асуудал бий. Түрүүн та бид нарын хоорондын ярилцлага дотроос бол Санхүүгийн зохицуулах хороо ч гэдэг юм уу ийм улсууд байгууллагуудын юм яригдаад байна лээ. Тэгэхээр зэрэг Их Хуралд ажлаа тайлагнадаг тэр байгууллагуудын хүрээнд гарчихсан тийм хууль тогтоомжууд байгаа эсэхийг нь Төсвийн байнгын хороо нь шалгаж үзээд, байвал хүчингүй болгохыг нь болгоод, хуульд нийцүүлэхийг нь нийцүүлээд ингээд зохицуул гэдэг үүргийг нь хэлээд тэгээд ерөөсөө 3 дахь заалтаараа бол харин энэ Засгийн газраас орж ирсэн асуудлыг нь ч тэр, энэ юунаас орж ирсэн асуудлыг нь ч тэр, нэгтгээд базаад танилцуулах чиглэлээ өгсөн ийм л заалттай байвал дээр юм уу л гэж бодоод байна шүү дээ. Би бүтцийнх нь хувьд.

**Г.Тэмүүлэн:** Ойлголоо. Батжаргал гишүүний саналыг зарчмын хувьд дэмжиж байна. Тэгээд саяын Батжаргал гишүүний гаргасан саналын томъёоллын дагуу найруулгын өөрчлөлтийг хийгээд батлах нь зүйтэй гэсэн саналтай байна. Батлахыг дэмжье гэсэн.

Ингээд энэ томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

Ингээд 70 хувиар дэмжигдлээ.

Тэгэхээр зарчмын зөрөөтэй саналын томъёолол дээр саяын тогтоолын төсөл дээр зарчмын зөрөөтэй саналын томъёолол гараагүй тул анхны хэлэлцүүлгээр эцэслэн батлах санал хураалтыг нэгтгэн явуулах горимын саналыг гаргаж байна. Тэгээд санал хураалтыг явуулъя.

60 хувиар дэмжигдлээ.

Ингээд Улсын Их Хурлын чуулган дээр Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг миний бие ингээд танилцуулъя.

Ингээд тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

18.35 цаг

Байнгын хороогоор хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдэж байна.

Баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ